



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/36

Хужирт сум

Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.16, 66 дугаар зүйлийн 66.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хог хаягдлын нэгдсэн цэг байгуулах газрын байршлыг судлан, төсөв тооцоог гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Дэмбэрэл (Засаг даргын орлогч)

Гишүүд: Б.Бямбасүрэн (Байгаль орчны Улсын хяналтын байцаагч)

Ц.Нямдорж (Газрын даамал)

Ж.Шижээ ("Хужирт эрдэс баялаг" УТҮГ-ын дарга)

Д.Мягмарсүрэн (4 дүгээр багийн Засаг дарга)

Ц.Лхамролом (5 дугаар багийн Засаг дарга)

Ч.Сонинбаяр (Байгаль хамгаалагч)

2. Холбогдох хууль тогтоомжийн дагуу газрын байршил тогтоон, төсөв тооцоог боловсруулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулахыг Ажлын хэсгийн ахлагч (Б.Дэмбэрэл)-д үүрэг болгосугай.



ДАРГА

Д.БАТБАЯР

622401071

D:Alban bichig;Zahiramj 2024